



200

ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 178

Баян-Өндөр сум

Хөтөлбөр батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1."Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын сургалтын 2022-2025 оны хөгжлийн хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.


2.Хөтөлбөрийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс хэрэгжүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр батлуулж, зохион байгуулах, хагас, бүтэн жилээр биелэлтийг тайлагнаж ажиллахыг тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Ариун-Эрдэнэ), архив, бичиг хэргийн эрхлэгч, хүний нөөцийн ажилтан (Ч.Болдцэцэг) нарт үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж, зориулалтын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Б.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАЯР

201
Биеийн тамир, спортын газрын даргын
20.22 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
10.28 дугаар тушаалын хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт төрийн байгууллага “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4 дүгээр зорилт “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ” гэж заасан байна.

Тус байгууллага нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлтөөр одоо ажиллаж байгаа төрийн үйлчилгээний дасгалжуулагч, мэргэжилтнүүдийг төрийн захиргааны албан хаагч руу шилжүүлэн ажиллуулах чиглэлтэй байгаа нь албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, давтан сургах шаардлагыг бий болгож байна.

Тус газарт ажиллаж байгаа албан хаагчдаас төрийн албаны шалгалтад тэнцэж төрийн захиргааны албан хаагчаар ажиллаж байгаа 3 албан хаагч, дээд боловсролын болон бакалаврын зэрэг шаардсан албан тушаалд ажиллаж байгаа 8 албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны ерөнхий шалгалтад тус байгууллагаас нийт 5 албан хаагч шалгалт өгсөнөөс 2020 онд 1 албан хаагч тэнцэж нөөцөд бүртгэгдсэн. Нөөцийн бүртгэлийн хугацаа нь 2022 оны 10 сард дуусна. Албан хаагчдын боловсролын түвшинг авч үзвэл магистр 2, бакалавр болон дээд боловсролтой 7, мэргэжлийн үнэмлэхтэй 10 албан хаагч байна.

Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох асуулга судалгааг албан хаагчдаас авахад ажил үүргээ гүйцэтгэх мэдлэгээ сайжруулах хүсэлтэй байгаа 16, шаардлагагүй 5, ажил үүргээ гүйцэтгэхэд хэрэгтэй мэдээллийг албан хаагчдын 9 нь байгууллагаас зохион байгуулсан сургалтаар, интернэтээс 9, бусад сургалтаас 6 гэж хариулсан. Шинэ мэдлэг эзэмшихэд албан хаагчдын 17 нь танхимаар, 6 албан хаагч цахимаар гэж хариулсан. Мөн ямар чиглэлээр сурах хэрэгтэй байгаа талаар: компьютерийн мэдлэгээ сайжруулах хүсэлтэй 12, албан бичиг боловсруулах 3, бусад талын мэдлэгээ дээшлүүлэх хүсэлтэй 11, гадаад хэл сурах хүсэлтэй 5, илтгэх ур чадвараа дээшлүүлэх 3, монгол бичиг сурах хүсэлтэй 5. Шинээр сурч эзэмшсэн мэдлэгээ ямар зорилгоор ашиглах шаардлагатай байгаа вэ гэдэг асуултад өөр ажил хавсран ажиллах хүсэлтэй 3, албан тушаал дэвших хүсэлтэй 4, ажлын гүйцэтгэл үр дүнгээ сайжруулах хүсэлтэй 12, боловсролын түвшингээ ахиулах хүсэлтэй 7 албан хаагч байна.

Иймд байгууллагын зүгээс албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж төрийн албаны болзол шалгуурыг хангуулах, албан тушаалын чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг чадварыг эзэмшүүлэх, бакалаврын боловсрол

эзэмшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго:

2.1.Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын мэдлэг боловсрол ур чадвар, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэн чиглүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалтад хамруулах, төрийн албаны стандарт, шаардлагад нийцэн ажиллах мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

Гурав.Хөтөлбөрийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх зарчим:

3.1.Албан хаагчдыг ажлын байранд нь сургах, өөр байгууллага, хамт олноос суралцах буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах, боловсролын, мэргэжлийн байгууллагад суралцуулах, мэргэжлээрээ дагнан суралцах гэсэн зарчимд тулгуурлан зохион байгуулна.

3.1.1.Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулахын сургалтын хөтөлбөрийг дараах чиглэлүүдээр зохион байгуулна.

1.Мэргэжлийн ур чадвар сайжруулах;

а.мэргэжлийн ажлаа хийж гүйцэтгэхэд дутагдаад байгаа ур чадварууд

- монгол бичиг, монгол хэлээр алдаагүй зөв бичих, унших;
- албан хэрэг боловсруулах арга зүй;
- мэдээллийн технологийн хөтөлбөртэй ажиллах чадвар;
- судалгаа хийх, дүгнэлт гаргах, асуудлыг шийдвэрлэх;
- салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
- хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулах;

б.төрийн албаны болзол шалгуурыг хангуулах;

в.ажил албан тушаалын гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг эзэмшүүлэх;

г.ажил албан тушаал сэлгэх болон түр орлон ажиллуулах мэдлэг чадварыг эзэмшүүлэх;

д.албан тушаал дэвшин ажиллахад шаардагдах боловсролыг эзэмшүүлэх;

е.төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт, мэргэшүүлэх багц сургалтад хамруулах;

2.Байгууллагын дотоод сургалт;

-байгууллагын зорилго, үзэл санаа, үнэт зүйл, соёл, дэг, журам, заавар, журам

3.Хувь хүний хөгжил;

-бие даан суралцах чадвар, хувийн зохион байгуулалт, дадал зуршил, амьдралын хэв маяг

4.Багаар хамтран ажиллах ур чадвар;

-бусадтайгаа уялдаж, ойлголцож ажиллах чадварын түвшин

3.1.2.Оны сүүлийн улиралд дараа жилийнхээ сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд хамт олноос судалгаа авах, ярилцлага хийх, байгууллага, нэгжийн зорилт, ажлын байрны тодорхойлолт, ажлын үзүүлэлт зэргийг харгалзан үзэх,

3.1.3.Шинэ залуу ажилтнуудыг мэдлэг, туршлагатай ажилтныг дагалдуулж сургах, төрийн албаны чиглүүлэх богино хугацааны сургалтад хамруулах,

3.1.4.Хүүхэд харах чөлөөтэй байгаа ажилтныг ажил, албан тушаалтай нь холбоотой сургалт, арга хэмжээнд тухай бүр хамруулах,

3.1.5.Албан хаагч бүр чиг үүрэг, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ өөрийн хүч, мэдлэг чадвараа дайчлан ажиллаж хамт олны дунд багаар ажиллах.

3.2.Орон нутгийн хамтарсан сургалт арга хэмжээ:

а) Удирдах дээд байгууллага болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтарсан сургалт семинарыг зохион байгуулахаар жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах,

б) Орон нутгийн захиргааны байгууллагаас санаачлан зохион байгуулагдах сургалтанд албан хаагчдыг ажлын чиг үүрэг, мэргэжлээр нь тогтмол хамруулах,

в) Ижил чиг үүрэг гүйцэтгэдэг бусад төв, орон нутгийн байгууллага, албан хаагчдаас туршлага судлах.

3.3. Давтан сургалт:

а) Албан хаагчдыг ажил үүрэг гүйцэтгэх болон хууль тогтоомжид зааснаар тодорхой хугацаанд мэргэшүүлэх сургалтад хамруулах,

б) Хүний нөөцийн мэдээллийн сан, судалгаанд үндэслэн албан хаагчдыг боловсролыг ахиулах талаар сургалтад дэс дараатай хамруулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт:

4.1.Хөтөлбөрийг 2022-2025 он хүртэлх дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

4.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсвөөс сургалтад зориулан хуваарилсан хөрөнгө

- Бусад эх үүсвэр

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт:

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг оны эхэнд батлуулж, үр дүнг тооцон ажиллана.

5.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд уялдуулан зохицуулж хэрэгжүүлнэ.

5.3.Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, албан хаагч бүрийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

5.4.Биеийн тамир, спортын газрын удирдлага нь албан хаагчийг сургах, давтан сургах, хөгжүүлэх, чадавхийг нь бэхжүүлэх нөхцөлөөр ханган дэмжлэг үзүүлэх, албан хаагч нь өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулахад хамтран ажиллах үүргийг тус тус гүйцэтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ:

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 6, 12 дугаар сарын 25-ны дотор дүгнэж, байгууллагын даргын дэргэдэх зөвлөлд танилцуулна.

6.2.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээг 2 жилд нэг удаа хийж байна, шаардлагатай бол хөтөлбөрт нэмэлт,өөрчлөлт оруулж болно.

6.3.Сургалтад хамрагдсадын судалгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтоол шийдвэрийн биелэлт хяналт шинжилгээ үнэлгээний асуудал мэргэжилтэн, хүний нөөцийн ажилтан хамтран хэрэгжүүлнэ.

6.4.Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр гаргана.

- а) төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан сургалтын тоо
- б) сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо /давхардсан тоогоор/
- в) шинэ ажилтныг дадлагажуулах талаар зохион байгуулсан ажлын тоо
- г) ажилтнууд сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглаж байгаа байдал
- д)байгууллагад нэвтэрсэн шинэ санаа, дэвшилтэт арга барил,ажлын туршлага
- е) албан хаагчид сургалт семинарт хамрагдсан үр дүн, дэвшүүлсэн зорилт, сургалтын хөтөлбөрийн гарсан үр дүн
- ё) гадаад, дотоодын сургалт, семинарт хамрагсадын тоо.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн:

7.1.Албан хаагчийн мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлэн мэргэжлийн онолын мэдлэгээ сайжруулснаар эрхэлсэн ажилдаа шинэ арга барилыг нэвтрүүлж, үр бүтээл гарах боломж бүрдэнэ.

7.2.Төрийн албаны болзол шалгуурыг хангасан мэргэшсэн албан хаагчтай болно.

7.3.Албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасан мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.

7.4.Ажилтан, албан хаагч бүр мэдлэг, чадвараа дээшлүүлж түүнийгээ хөгжүүлж, сайжруулахын төлөө ажилласан байна.

7.5.Ажилтан, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломж нэмэгдэнэ.

7.6.Мэдлэг, чадвартай, мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлснээр байгууллагын чиг үүргийн хүрээнд шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

7.7.Байгууллагад албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах тогтолцоо бүрдэж албан хаагчид байнга суралцан хөгжих боломж, нөхцөл хангагдана.

7.8.Төрийн албаны тухай болон бусад хууль, тогтоомжийг хэрэгжилт хангагдана.

7.9.Дараагийн хөтөлбөр боловсруулах үндэс, суурь нь болж мөн уг хөтөлбөрийн үргэлжлэл болно.